МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр Дугаар А/287 Мөрөн сум

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Манай орны зүүн, баруун болон төвийн бүсийн зарим аймагт мал, амьтны гоц халдварт үхрийн арьс товруутах, бог малын мялзан, шүлхий, хонины цэцэг өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан өвчин зөөвөрлөгдөн, дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт бүх төрлийн мал, амьтны орох шилжилт хөдөлгөөнийг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 2023 оны 01 дүгээр сарын 01- ний өдрийг хүртэлх хугацаагаар хориглосугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх, батлагдсан журам, удирдамж зааврын хүрээнд малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгаж, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Д.Нямдорж), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газрын дарга (хурандаа Т.Ганхуяг), Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ё. Пүрэвсүрэн), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш. ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022